



ГАДААДАД СУРАЛЦАЖ БУЙ МОНГОЛ ИРГЭДИЙН ЗАРДЛЫН ТҮҮВЭР СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ ТАЙЛАН

Боловсруулсан: ВЭЗГ-ын эдийн засагч Т.Түвшингэрэл

ХУРААНГУЙ


Түүвэр судалгааг цахим хэлбэрээр зохион байгуулж, гадаад орнуудад суралцаж буй нийт 437 Монгол иргэдийг санамсаргүй түүврийн аргаар сонгон хамрууллаа. Судалгааны үр дүнгээс үзэхэд, судалгаанд хамрагдсан Монгол оюутнууд жилд дунджаар 0.8-16.8 мянган ам.долларыг сургалтын төлбөрт, 3.0-12.0 мянган ам.долларыг хувийн хэрэгцээнд тус тус зарцуулж, нийт дунджаар 4.6-27.5 мянган ам.долларын өртөгтэйгөөр суралцаж байгаагийн 20 орчим хувийг орноосоо хүлээн авдаг байна.

I. СУДАЛГААНЫ ЗОРИЛГО

Монгол Улсын төлбөрийн тэнцлийн үйлчилгээний дансанд гадаадад суралцаж буй Монгол иргэдийн сургалтын төлбөр, байр хоол, унааны болон бусад зардлыг оруулан тооцдог. Өнөөдрийн байдлаар энэхүү дансны мэдээллийн эх сурвалжаар зөвхөн банкуудын гадаад гүйлгээний тайланг ашиглаж байна. Иймд гадаадад суралцаж буй Монгол иргэдийн зардлыг тодорхойлж, холбогдох аргачлалыг боловсруулах, улмаар төлбөрийн тэнцлийн мэдээллийн хамрах хүрээг нэмэгдүүлэх, чанарыг сайжруулахад энэхүү судалгааны зорилго оршино.

II. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Дүрслэл 1. Гадаадад суралцахаар зорчсон иргэд (Улсаар)



Эх сурвалж: ХХЕГ

Хил хамгаалах ерөнхий газрын 2012 оны мэдээгээр тус онд ойролцоогоор 24 мянган иргэд гадаадад суралцах зорилгоор Монгол Улсын хилээр гарсан⁶⁵ бөгөөд энэ тоо сүүлийн 3 жил тогтвортой байна. Түүнчлэн “Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллого”⁶⁶-оор 40 орчим мянган иргэд гадаадад суралцаж байгаа дүн гарсан. Дээрх тоонуудыг нэгтгэн дүгнэвэл гадаадад суралцаж буй иргэдийн 70 орчим хувь нь БНХАУ, ОХУ, БНСУ, Япон болон АНУ-д суралцаж байна.

⁶⁵ Давхардсан тоогоор. “2012 онд гадаадад зорчсон Монгол иргэдийн судалгаа”, Хил хамгаалах ерөнхий газар.

⁶⁶ Монгол Улсын үндэсний статистикийн хорооноос боловсруулсан.

Хүснэгт 1. Төлбөрийн тэнцлийн хураангуй хүснэгт

I. УРСГАЛ ТЭНЦЭЛ

A. Бараа ба үйлчилгээний худалдаа

2. Үйлчилгээ

2.2 Аялал

2.2.1 Албан томилолт

2.2.1.1 Ажиллагсдын зардал

2.2.1.2 Бусад

2.2.2 Хувийн аялал

2.2.2.1 Эмчилгээний зардал

2.2.2.2 Сургалтын зардал

2.2.2.3 Бусад

B. Орлого

C. Урсгал шилжүүлэг


II. ХӨРӨНГӨ БА САНХҮҮГИЙН ТЭНЦЭЛ

A. Хөрөнгийн данс

B. Санхүүгийн данс

III. АЛДАА БОЛОН ОРХИГДУУЛГА

Дүрслэл 2. Аяллын үйлчилгээний дансны тэнцэл




Монгол Улсын төлбөрийн тэнцлийн статистикт сургалтын үйлчилгээний орлого, зарлагыг үйлчилгээний дэд данс дахь аяллын үйлчилгээний дансанд бүртгэдэг бөгөөд 2012 оны байдлаар сургалтын үйлчилгээний цэвэр дүн 59 сая ам.долларын алдагдалтай гарсан нь тайлант онд харьяат бустай хийсэн аяллын үйлчилгээний нийт алдагдлын 44%-ийг эзэлж байна. Гэвч энэ нь зөвхөн банкны системээр дамжин хийгдэж байгаа гадаад гүйлгээний тоон мэдээлэлд суурилсан үзүүлэлт тул бодит дүнгээс бага байх магадлалтай юм.

III. СУДАЛГААНЫ АРГАЗҮЙ, ТҮҮВЭР

Судалгааны анкетийг цахим хуудсанд байршуулан⁶⁷, судалгаа авах хүсэлтийг гадаадад суугаа Монгол иргэд ихээр зочилдог цахим хуудас, гадаад улс орнууд дахь Монгол оюутны холбоод, фэйсбүүк, твиттер зэрэг олон нийтийн харилцааны сүлжээ, найз нөхдийн шугамаар дамжуулан түгээж, нийт 437 Монгол оюутныг санамсаргүй түүврийн аргаар сонгон хамрууллаа.

⁶⁷ Судалгааны цахим маягтай дараах холбоос (<http://tinyurl.com/bpz6b3s>) эсвэл хавсралтаас танилцана уу.


Дүрслэл 3. Эх олонлог ба түүврийн бүтцийн харьцуулалт




* Бусад Азийн оронд Тайвань, Тайланд, Малайз, Сингапур, Гонг-Конг, болон Казакстан орно.

Монгол Улсын хилээр “суралцах” зорилгоор 2010-2012 онуудад гарсан иргэдийн мэдээлэлд суурилан түүвэрт хамруулах голлох улсуудыг сонгон түүвэрлэлтийг гүйцэтгэж, үр дүнг нэгтгэсэн. Улс тус бүрийн хувьд түүвэр нь эх олонлогийн 1-8%-ийг хамарч, эх олонлогийг тайлбарлах чадвартай байна.

Дүрслэл 4. Судалгааны талаарх мэдээллийг авсан эх сурвалж




Дүрслэл 5. Нас, хүйсийн харьцаа



Олон нийтийн сүлжээ, ялангуяа фэйсбүүкээр дамжуулан судалгааны талаарх мэдээллийг авсан иргэд оролцогчдын дийлэнх хувийг эзэлж байна. Судалгаанд хамрагдагсдын хүйсийн харьцаа ойролцоо байсан бөгөөд бакалаврын зэрэг горилогсдын хувьд дундаж наслалт 18-25, магистр, докторын зэрэг горилж буй хүмүүсийн хувьд 26-33 байна.

Дүрслэл 6. Суралцагчдын горилж буй зэрэг



Хүснэгт 2. Суралцсан болон суралцах хугацаа


	Суралцсан жил				
	0-1	2-4	4+	Нийт	
Суралцах жил	0-1	5%	16%	17%	37%
	2-4	10%	22%	15%	47%
	4+	7%	7%	3%	16%
	Нийт	22%	44%	35%	100%

Судалгаанд хамрагдсан оюутнуудын 91 хувийг бакалавр болон магистрын зэрэг горилогсад эзэлж байсан бөгөөд нийт хамрагдсан оюутнуудын 65 орчим хувь нь цаашид 2 ба түүнээс дээш жилийн хугацаатайгаар суралцах төлөвлөгөөтэй байна. Иймээс судалгааны үр дүн ирэх 2 жилдээ тогтвортой байх хандлагатай байна.

IV. СУДАЛГААНЫ НЭГДСЭН ДҮН


Оюутнуудын сургалтын төлбөр болон амжиргааны зардал нь суралцаж буй улсаас хамааран ихээхэн ялгаатай байна. Нэг оюутны жилийн дундаж сургалтын төлбөр нь тэтгэлэггүй тохиолдолд дунджаар 1.1-21.7 мянган ам.доллар байх ба сургалтын төлбөрийн тэтгэлэг авсан байдлаар жигнэн тооцоолвол 1 оюутан ойролцоогоор 0.8-16.8 мянган ам.долларын зардлыг жилийн сургалтын төлбөрт

Дүрслэл 7. Оюутны 1 жилийн нийт зардал




төлдөг дүн гарсан. Амжиргааны зардлын хувьд ойролцоогоор 3.0-12.0 мянган ам.долларыг хувийн хэрэгцээнд зарцуулдаг байна.

Дүрслэл 8. Сургалтын зардлын тэтгэлэгт хамрагдсан байдал болон дундаж төлбөр




Дүрслэл 9. Амжиргааны зардлын тэтгэлэгт хамрагдсан байдал болон 1 сарын дундаж зардал




Сургалтын зардлын тэтгэлэгт хамрагдсан байдлаар авч үзвэл судалгаанд оролцогчдын 50 орчим хувь нь тодорхой хэмжээгээр сургалтын төлбөрөөс чөлөөлөгдсөн, эсвэл сургалтын тэтгэлэгт хамрагдсан байсан ба түүврийн дүнгээс үзвэл хамгийн өргөнөөр тэтгэлэг олгодог оронд ОХУ, хамгийн тэтгэлгийн олдоц багатай оронд Энэтхэг болон Герман улс орж байна. Амжиргааны зардлын хувьд хувийн зардлаар байр, хоолны төлбөрөө санхүүжүүлдэг оюутнууд дийлэнх хувийг эзэлж байна.

Дүрслэл 10. Оюутнуудын цагийн ажил эрхэлдэг байдал




Дүрслэл 11. Амжиргааны дундаж зардал



Сургалтын төлбөр болон амжиргааны зардлыг санхүүжүүлэх бас нэг эх үүсвэр бол суралцахын хажуугаар цагийн ажил хийх явдал юм. Тухайн улс орны хууль эрхзүйн зохицуулалтаас шалтгаалан оюутнуудын цагийн ажил эрхлэх боломж харилцан адилгүй байдаг бөгөөд судалгаанд оролцогчдын хариултаас үзвэл

Дүрслэл 12. Мөнгө хүлээн авдаг давтамж болон 1 жилд авдаг дундаж хэмжээ



хөгжингүй орнуудад гадаад оюутнууд цагийн ажил хийх боломж болон хандлага өндөр байдаг болох нь харагдсан. Ажил эрхэлж буй байдал болон амьдарч буй хотын хэмжээнээс шалтгаалан амжиргааны зардлын хэмжээ төдийлөн өөрчлөгдөхгүй байна.

Оюутнууд тэтгэлэгт хамрагдах, цагийн ажил хийхээс гадна сургалтын зардлын тодорхой хувийг эх орноосоо гуйвуулан авдаг. Гуйвуулгын давтамж, 1 удаад хүлээн авч буй мөнгөн дүн,

гуйвуулга хүлээн авдаг оюутнуудын хувийн жин зэргийг харгалзан 1 жилийн хугацаанд гэрээсээ хүлээн авдаг гуйвуулгын хэмжээг тооцоолвол 1 оюутан дунджаар 1.2-3.7 мянган ам.долларыг авдаг байна. Өөрөөр хэлбэл 1 оюутан суралцаж буй улсаас хамааран жилд 4.6-27.5 мянган ам.долларын өртөгтэйгөөр суралцаж байгаа бөгөөд үүний 20 орчим хувийг гэрээсээ хүлээн авч, үлдсэн зардлыг тэтгэлэг болон цагийн ажлын цалингаар төлж байгаа дүн гарлаа.

Дүрслэл 13. Мөнгө хүлээн авахад ашигладаг гуйвуулгын үйлчилгээний төрөл



Шилжүүлгийг олон улсын карт, банкны гуйвуулгын үйлчилгээ зэрэг гадаад гүйлгээний тайланд тусгагддаг арга хэрэгслүүдээс гадна хувь хүн болон гуйвуулгын үйлчилгээ эрхэлдэг ББСБ-уудаар⁶⁸ дамжуулан шилжүүлэх зэрэгбусад сувгийг ашигладаг байна.

⁶⁸ Санхүүгийн зохицуулах хорооны тусгай зөвшөөрөлтэйгөөр мөнгөн гуйвуулгын үйлчилгээ эрхэлдэг банк бус санхүүгийн байгууллага нь 2012 оны сүүлийн байдлаар 4 байгаа бөгөөд үүнээс “Шинэ төгрөг” болон “Мөнгөн гүүр”-ээр дамжуулан хийгддэг гүйлгээ нь гадаад гүйлгээний тайланд албан ёсоор тусгагддаг. Бусад ББСБ-уудын хувьд (зөвшөөрөлгүйгээр үйлчилгээ эрхэлдэг байгууллагуудыг хамруулан) дотоодын арилжааны банкуудаар дамжуулан шилжүүлэг хийсэн тохиолдолд тайланд тусгагдах ба гадаадын банкаар дамжуулан, эсвэл бусад аргаар шилжүүлсэн тохиолдолд тайланд тусгагддаггүй.

ҮР ДҮН

Судалгаанд хамрагдсан оюутнууд нь суралцаж буй улсаас хамааран 1 жилд дунджаар 0.8-16.8 мянган ам.долларыг сургалтын төлбөрт, 3.0-12.0 мянган ам.долларыг хувийн хэрэгцээнд тус тус зарцуулж, нийт дунджаар 4.6-27.5 мянган ам.долларын өртөгтэйгөөр суралцаж байна.

Үүний 20 орчим хувийг гэрээсээ хүлээн авч, үлдсэн зардлыг тэтгэлэг болон цагийн ажил эрхлэн төлж байна. Оюутан нь 1 жилд ойролцоогоор 1.2-3.7 мянган ам.долларыг эх орноосоо хүлээн авдаг бөгөөд үүний 70 орчим хувийг банкны системээр дамжуулан авдаг бол үлдсэн хэсгийг хувь хүн, карго гэх мэт гуйвуулгын бусад арга хэрэгслээр дамжуулан авч байна.

Судалгаанд хамрагдсан оюутнуудын 65 орчим хувь нь цаашид 2 ба түүнээс дээш жилийн хугацаатайгаар суралцах төлөвлөгөөтэй байна. Иймээс судалгааны үр дүн ирэх 2 жилдээ тогтвортой байх хандлагатай байна.

ГАДААДЫН УЛС, ОРНУУДАД СУРАЛЦАЖ БУЙ МОНГОЛ ИРГЭДИЙН ЗАРДЛЫН СУДАЛГААНЫ АНКЕТ

Гадаадад суралцаж буй Монгол оюутнуудын сургалтын төлбөр, амжиргааны зардлыг тодорхойлж, улс орны эдийн засагт нөлөөлж буй нөлөөллийг тооцох, статистик мэдээллийн чанарыг сайжруулах зорилгоор Монголбанк (Төв банк)-наас зохион байгуулж буй энэхүү судалгаанд Таныг идэвхтэй оролцож, бидний ажилд гүн туслалцаа үзүүлнэ гэдэгт итгэж байна.

1. Таны суралцаж буй улс: (Нөхөх)....
2. Таны суралцаж буй хотын нэр: (Нөхөх)....
3. Та сурахын хажуугаар ажилладаг уу?

А. Тийм	Б. Үгүй
---------	---------
4. Таны горилж буй боловсролын зэрэг юу вэ?

А. Бакалавр	Б. Магистр
В. Доктор	Г. Бусад
5. Та тус улсад хэдэн жил суралцаж байна вэ?

А. 1 жил	Б. 2-3 жил
В. 4 буюу түүнээс дээш жил	
6. Та цаашид хэдэн жил суралцах вэ?

А. 1 жил хүртэл	Б. 2-3 жил
В. 4 буюу түүнээс дээш жил	
7. Сургалтын төлбөрийн хэдэн хувийг тэтгэлгээр санхүүжүүлсэн бэ?

А. 0-30	Б. 31-50
В. 51-70	Г. 71-100
8. Та сургалтын төлбөрөө хэрхэн санхүүжүүлсэн бэ?

А. Хувийн зардлаар	Б. Тэтгэлгээр
В. А, Б-г хослуулан	
9. Зардалтай холбоотой асуултуудад хариулахдаа ашиглах валютыг сонгоно уу?

USD АНУ-ын доллар	TRY Туркийн лира
EUR Евро	CNY БНХАУ-ын юань
JPY Японы иен	KRW БНСУ-ын вон
CHF Швейцарийн франк	CAD Канадын доллар
SEK Шведийн крон	AUD Австралийн доллар
GBP Английн фунт	CZK Чехийн крон
INR Энэтхэгийн рупи	NZD Шинэ Зеландийн доллар
RUB ОХУ-ын рубль	Бусад:
10. 1 жилд таны хувийн зардлаар санхүүжүүлдэг сургалтын төлбөрийн хэмжээ хэд вэ? (Нөхөх)

11. Та нэг сарын амжиргааны зардалдаа нийт хэдий хэмжээний мөнгө зарцуулдаг вэ? (Үүнд байр, хоол хүнс болон бусад бүх төрлийн зардлыг оруулна)
12. Та амжиргааны зардлаа хэрхэн санхүүжүүлдэг вэ?
А. Хувийн зардлаар Б. Тэтгэлгээр В. А ба Б
13. Та гэрээсээ хувийн хэрэгцээний мөнгө хүлээн авах, эсхүл гэр рүүгээ мөнгө шилжүүлдэг үү? (2 сонголт хийж болно)
А. Хүлээн авдаг Б. Шилжүүлдэг
В. Хүлээн авдаг
14. Хэрэв хүлээн авдаг бол нэг удаад хэдий хэмжээний мөнгө хүлээн авдаг вэ?
.....
15. Ямар давтамжтай хүлээн авдаг вэ?
А. Жилд 1-2 удаа Б. Улиралд 1-2 удаа
В. Сард 1-2 удаа Г. Бусад
16. Хэрэв шилжүүлдэг бол нэг удаад хэдий хэмжээний мөнгө шилжүүлдэг вэ?
.....
17. Ямар давтамжтай шилжүүлдэг вэ?
А. Жилд 1-2 удаа Б. Улиралд 1-2 удаа
В. Сард 1-2 удаа Г. Бусад
18. Гуйвуулга хийхдээ ямар үйлчилгээг ашигладаг вэ? (олон сонголт хийж болно)
А. Банкны гуйвуулгын үйлчилгээ (Money Gram, Western Union)
Г. Хувь хүнээр дамжуулан
Д. Олон улсын картаар (VISA, Master гэх мэт)
Е. Гуйвуулгын үйлчилгээ эрхэлдэг банк бус санхүүгийн байгууллага
Е. Бусад (бичих):
19. Таны нас:
А. 18 хүртэлх Б. 18-25
В. 26-33 Г. 34-40
Д. 40-өөс дээш
20. Таны хүйс: Эрэгтэй Эмэгтэй
21. Уг асуулгын талаарх мэдээллийг та хаанаас авсан бэ?
(Оюутны Холбоо, Фэйс бүүк, Твиттер, gogo.mn, найз гэх мэт)

Судалгаанд оролцсон танд баярлалаа